



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/173

Мөрөн сум

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Биеийн тамир спортын тухай хуулийн 8.1.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, 15 дугаар зүйлийн 1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.4, 2.1.6, 4.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 13 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монголын Пауэрлифтингийн нэгдсэн холбооны тамирчин Ц.Отгондалай Америкийн Нэгдсэн Улсын Аустин хотод болох хэвтээ шахалтын дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд 1,000,000 (Нэг сая), Сагсан бөмбөгийн холбооны баг тамирчид Дархан хотод болох U17 насны Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд 500,000 (Таван зуун мянга), “Шагайн харваан-2024” аймгийн аварга шалгаруулах тэмцээний зардалд 1,500,000 (Нэг сая таван зуун мянга), “Чингүн” боксын клубын баг тамирчид Өмнөговь аймагт болох Өсвөрийн боксын Улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох зардалд 500,000 (Таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсүгэй.

2. Дээрх дэмжлэгийн 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн) -т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж2024

6713010552